ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

БАТЛАВ
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА
Ц.БАТЗУЛ

БАТЛАВ
“ТЕХНО ЗОН”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Д.СЕРИЮКАН

# “БОЛОВСРОЛЫН САЛБАРТ СУРГАЛТЫН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ СУУРИН БОЛОН ЗӨӨВРИЙН КОМПЬЮТЕР БУСАД ЦАХИМ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН” ХУДАЛДАН АВАХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

Дугаар № ТХААГ/202203009/ЕГ/04/04

2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас Төрийн худалдан авах ажиллагааны газар (цаашид “мэргэжлийн байгууллага” гэх), нөгөө талаас “Техно зон” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр энэхүү ЕРӨНХИЙ ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу Ерөнхий гэрээгээр Боловсролын салбарт сургалтын зориулалтаар ашиглах суурин болон зөөврийн компьютер, бусад цахим хэрэглэгдэхүүн нийлүүлэхтэй холбоотой мэргэжлийн байгууллага, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Мэргэжлийн байгууллага нь **“Боловсролын салбарт сургалтын зориулалтаар ашиглах суурин болон зөөврийн компьютер, бусад цахим хэрэглэгдэхүүн худалдан авах”** гэх бараа нийлүүлэх тендер шалгаруулалтыг зохион байгуулж доорх нэгж үнээр (цаашид “гэрээний нэгж үнэ” гэх) цахим дэлгүүрт байршуулахыг үүгээр хүлээн зөвшөөрөв.

| Багц | Барааны нэр | Нэгж үнэ | |
|---|---|---|---|
| | | Тээвэрлэлтийн зардал ороогүй нэгж үнэ /төгрөг/ | Тээвэрлэлтийн зардал орсон нэгж үнэ /төгрөг/ |
| Багц-4: | Зөөврийн компьютер /i3/ | 2,270,000 /Хоёр сая хоёр зуун далан мянга/ | 2,270,000 /Хоёр сая хоёр зуун далан мянга/ |
| Багц-5: | Зөөврийн компьютер /i5/ | 2,970,000 /Хоёр сая есөн зуун далан мянга/ | 2,970,000 /Хоёр сая есөн зуун далан мянга/ |
| Багц-6: | Зөөврийн компьютер /i7/ | 4,070,000 /Дөрвөн сая далан мянга/ | 4,070,000 /Дөрвөн сая далан мянга/ |
| Багц-32: | Ухаалаг самбар 65" | 9,870,000 /Есөн сая найман зуун далан мянга/ | 9,870,000 /Есөн сая найман зуун далан мянга/ |

3. Нийлүүлэгч нь “Боловсролын салбарт сургалтын зориулалтаар ашиглах суурин болон зөөврийн компьютер, бусад цахим хэрэглэгдэхүүн худалдан авах” төсөл, арга хэмжээний барааг Ерөнхий гэрээний хүчинтэй хугацаанд буюу 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийг хүртлэх хугацаанд нийлүүлнэ.
4. Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтын арга болох **“үнийн санал авах”** ажиллагааны дагуу захиалагчаас Цахим дэлгүүрт ирүүлсэн худалдан авалтын захиалгын хуудаст заасан барааг нийлүүлэхээр шалгарсан тохиолдолд нийлүүлэгч нь Ерөнхий гэрээний дагуу бараа бүтээгдэхүүн худалдан авах гэрээг тухайн захиалагчтай байгуулна.
5. Нийлүүлэгч нь энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн барааг нийлүүлж, доголдол, дутагдлыг арилгах үүрэг хүлээнэ.

6. Ерөнхий гэрээний нэгж үнэ нь өөрчлөгдөхгүй, тогтмол байх бөгөөд худалдан авалтын гэрээний нэгж үнэ ерөнхий гэрээний нэгж үнээс ихгүй байна.

7. Гэрээнд холбогдох асуудлаар талууд зөвхөн албан бичгээр харилцана.

8. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
   - ✓ Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   - ✓ Тендер ба үнийн хуваарь;
   - ✓ Гэрээний ерөнхий нөхцөл;
   - ✓ Гэрээний тусгай нөхцөл;
   - ✓ Техникийн тодорхойлолт;
   - ✓ Эрх хязгаарлахыг зөвшөөрсөн мэдэгдэл;
   - ✓ Барааны өртгийн задаргаа эсхүл үнэ тогтмол байх тухай мэдэгдэл;
   - ✓ Бусад шаардлагатай баримт бичиг;

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

| | |
|---|---|
| Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга<br>Б.Буяннэмэх<br><br>Мэргэжлийн байгууллагыг төлөөлж:<br>Цахим худалдан авах ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн<br>Б.Чойсүрэн<br>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө-16А, Засгийн газрын IX байр, Төрийн худалдан авах ажиллагааны газар<br>Харилцах утас: 263026 | Нийлүүлэгчийн төлөөлж:<br><br>Гүйцэтгэх Захирал<br><br>Д.Серикжан<br><br>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Сайн ноён хан Намнансүрэнгийн гудамж 1/1а тоот<br><br>Харилцах утас: 99151820, 77011818<br><br>Банкны дансны мэдээлэл:<br><br>/Хаан банк:5447062496/ |